



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын Г  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эвээр Засах ХХК "Вашингтон" зочид буудлын 13/235, Монгол киёши ХХК "Тэмүүжин" зочид буудлын 15/042, Зориг халиун ХХК "Бэлх" дэн буудлын 14/110, Сайхан хүлэг ХХК "Хүлэг" дэн буудлын 14/030, Өнө бар ХХК "Өнө бар" дэн буудлын 13/190, Лайт кристал ХХК "Кристал" дэн буудлын 14/106, Иргэн Ц.Уранбилэгийн "Буудай" дэн буудлын 13/237 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд

1150500130

төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batm* Д БАТСҮХ



1117139265  
УОА0453 5284325

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 04 сарын 11-  
ний өдрийн А/32 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.04.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монгол киёши ХХК	2831813	Тэмүүжин	БЗД-ийн 4-р хороо Энхтайваны өргөн чөлөө 44
2	Эвээр засах ХХК	5631858	Вашингтон	БЗД-ийн 6-р хороо Энхтайваны өргөн чөлөө 41

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 04 сарын 11-  
ний өдрийн А/32 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.04.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Өнө бар ХХК	5378761	Өнө бар	ЧД-ийн 14-р хороо Хайлаастын 11-197
2	Сайхан хүлэг ХХК	5276527	Хүлэг	БЗД-ийн 25-р хороо Манлайбаатар дамдинсүрэнгийн гудамж 34-1
3	Лайт кристал ХХК	5165318	Кристал	СХД-ийн 31-р хороо Хайрханы 2/59
4	Зориг Халиун ХХК	5037298	Бэлх	СБД-ийн 18-р хороо 35-51а
5	Иргэн Ц.Уранбилэг		Буудай	БЗД-ийн 7-р хороо 3-21

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 04 сарын 11-ний өдрийн А/32 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.04.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хос шинэс ХХК	6024742	Хос шинэс амралт, сувилалын газар	СБД-ийн 20-р хороо Сэлх зуслангийн эцэс

-ооОоо-